МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн

МОНГОЛ УЛСЫН
“ЧИНГИС ХААН”
ҮНДЭСНИЙ МУЗЕЙ

ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн

МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ:
ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

VI

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан

Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2023 оны 4 сарын 19-21
Монгол Улс, Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Улаанбаатар – Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Хариуцлагатай редактор: Академич С. Чулуун
Эмхтгэгч-редакторууд: Хэл бичгийн шинжлэх ухааны доктор И. В. Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D), проф Н. Хишигт
Хэл шинжлэлийн дэд эрдэмтэн Д. А. Носов

Монголчуудын соёлын өв: Гар бичмэл ба архивын баримтын цуглуулга-VI. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2023 оны 4 сарын 19-21. Монгол Улс, Улаанбаатар хот. Улаанбаатар – Санкт - Петербург, 2025. – 320 тал.

Тус эмхэтгэлийг Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, “Чингис хаан” Үндэсний музей, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн хамтран 2023 оны 4 дүгээр сарын 19-21-нд Монгол Улсын Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, улс төр, хэл, утга зохиол, шашин соёл, угсаатны зүйд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2025
© Монгол Улсын “Чингис хаан” Үндэсний музей, 2025
© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2025

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

“ЧИНГИС ХАН”
Национальный музей
Монголии

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей

КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

VI

Международная конференция
при поддержке Президента Монголии

19-21 апреля 2023 г.
Монголия. Улан-Батор

Сборник докладов

Улан-Батор — Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Ответственный редактор: Академик С. Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И. В. Кульганек
доктор (Ph.D), проф. Н. Хишигт
кандидат филол. наук Д. А. Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов VI Международной научной конференции. 19-21 апреля 2023. Улан-Батор, Монголия. УБ. — СПб., 2025. — 320 с.

Сборник представляет собой собрание докладов VI Международной научной конференции “Культурное наследие монголов: рукописные и архивные собрания», организованной Институтом истории и этнологии МАН, Национальным музеем Монголии Чингис-хан и Институтом восточных рукописей РАН в Улан-Баторе 19-21 апреля 2023 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, политике, языку, литературе, культуре, религии и этнографии монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Институт истории и этнологии МАН, 2025
© "Чингис-хан" Национальный музей Монголии, 2025
© Институт восточных рукописей РАН, 2025

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology

CHINGGIS KHAAN
NATIONAL MUSEUM
OF MONGOLIA

RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts

CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

VI

International Conference
Under the Patronage of the President of Mongolia

April 19-21, 2023.
Mongolia, Ulaanbaatar

Proceedings

Ulaanbaatar – St. Petersburg
2025

ННА 63
ДАА 900
М-694

Edited and compiled by Academician S. Chuluun
D.Sc.(Philology) I. V. Kulganek
Ph.D (History), prof N. Khishigt
Cand. Sc. (Philology) D.A. Nosov

Cultural heritage of the Mongolis: Manuscripts and archival collections-VI. Papers of the VI International Conference, April 19-21, 2023. Ulaanbaatar. Ulaanbaatar-St.Petersburg 2025, 320 pages.

This is a collection of papers, presented at the Sixth International Conference organized by the Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences, National Museum of Mongolia "Chinggis Khaan" and the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, which was held in Ulaanbaatar in April 19-21, 2023.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-533-04-5
10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Institute of History and Ethnology MAS, 2025
© National Museum of Mongolia "Ghinggis Khaan", 2025
© Institute of Oriental Manuscripts RAS, 2025

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ

ӨМНӨХ ҮГ 10

МЭНДЧИЛГЭЭ /ПРИВЕТСТВИЯ..... 11

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дугаар удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогсдод ирүүлсэн илгээлт..... 12

Приветственная речь Генерального секретаря Международной ассоциации монголоведения, директора Национального музея Монголии Чингис-хан, академика С. Чулууна 14

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И. Ф. Поповой 16

Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, (Sc.D) Ц. Цэрэндоржийн мэндчилгээ..... 18

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх
Нур ад-Дины гар бичмэл дундад зууны монгол хүний нэрийн сурвалж болох нь 22

Г. Баярмаа
Берлиний Улсын номын санд хадгалагдах Монголын бурханы шашинд холбогдох баримтын тухай..... 28

Т. Баясгалан
Арташид хан хөвгүүний туужаас сэдэвлэсэн монгол тууль 43

Л. Ганбат
“Zafarnama” Монголын түүхэнд холбогдох сурвалж болох нь..... 52

Д. Дашдулам
1932 оны зэвсэгт бослогын нэгэн удирдагч Самбуу дүвчингийн тугийн талаар нэхэн үзэх нь 58

Ц. Дэлгэрсайхан
Монгол Улсын боловсролд Оросын сургагч багш, мэргэжилтнүүдийн оруулсан хувь нэмрийг архивын баримтаар тодотгох нь (1912-1942 он)..... 76

Zsolt Szilágyi
The Hungarian press perceptions of Mongolia at the beginning of the 20th century..... 89

И. М. Захарова
Караван купца Ивана Саватеева в Китай в 1702-1704 гг.
(По материалам Государственного Эрмитажа)..... 99

И. В. Кульганек
«Речь о состоянии монгольской словесности» из собрания
Института восточных рукописей РАН 108

Лицю Лю, Р. М. Валеев, Р. З. Валеева, Ю. И. Елихина, Д. Е. Мартынов
Формирование монголоведения, буддологии и тибетологии
в Казани в XIX в.: архивные фонды и материалы государственного
архива Республики Татарстан и музеев Казани 120

М. В. Мандрик
Коллекция документов по истории Русской духовной миссии
в Пекине и Монголии в собрании Научного архива ИИМК РАН 140

Д. Наранцэцэг
Хорчинба Ишжамцын намтар “Сүсэг төгөлдөр нугуудын зүрхний
энэлгийг арилгагч” хэмээх зохиолын шинжлэл 149

Б. Нацагдорж
Монгол Гэсэрийн туужийн үйсэн дээр бичсэн нэгэн эхийн тухай 162

Д. А. Носов
Загадка тетрадей Лисовского: о составе единицы хранения
« В.И. Лисовскийн тэмдэглэлийн дэвтэрүүд» из Центрального
Национального Архива Монголии 178

G.Odbayar
A Contribution to the study of Mongol bannermen: The founding policy
of the Tibetan Qing Administration, written by Sungyun 184

Э. Пүрэвжав, М. Очирцэнд
Монгол Улс дахь нутгийн аялгуу судлалыг архивын баримтаас
тодруулах нь 197

Т. Сайнжаргал
Үндэсний Төв Архивын сан хөмрөг дэх Түшээт засаг
гүн Балдардоржийн захидлын мэдээг мөшгөх нь 213

М. В. Федорова
Вклад Я. П. Шишмарева в формирование монгольского собрания
Российского этнографического музея 221

Н. Хатанбаатар
"Богд Жибзундамбын анхан төрлийн нэр оршивой" хэмээх сурвалжийн тухай 235

Н. Хишигт
О. И. Макстенек: Монголын тухай илтгэл, мэдээллүүд (1920-1921 он) 241

С. Цолмон, Ц. Энхчимэг
Еще раз о Золотоордынских тамгах Крыма 250

Ц. Цэрэндорж
Солонгосын Чосөнъ улсын үед монгол хэлний сургалтад ашиглаж байсан ном, сурах бичгүүдийн нэрийг тодруулах нь 262

S. Chuluun, Agata Bareja-Starzyńska
On the documents of the first population and statistical census of Mongolia in the 20th century kept in the archive of prof. W.Kotwicz in Cracow, Poland 274

Ц. Энхжаргал
Таван жилийн төлөвлөгөөг сайжруулах асуудалд холбогдох баримтын тойм (Монгол Улсын Үндэсний Төв Архивын материалаар) 291

ИЛТГЭГЧДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ 310

DOI 10.48612/IVRRAN/h118-e169-9ezh

Э. Пүрэвжав, М. Очирцэнд
(Монгол Улс)

МОНГОЛ УЛС ДАХЬ НУТГИЙН АЯЛГУУ СУДЛАЛЫГ АРХИВЫН БАРИМТААС ТОДРУУЛАХ НЬ

Товч агуулга: Монгол хэл шинжлэлийн нэгэн салбар ухаан болох нутгийн аялгуу судлах баримтжуулах ажил Монгол Улсад Судар бичгийн хүрээлэн анхлан байгуулагдсан даруй тус хүрээлэнгийн эрдэмтэд хөдөө орон нутагт хээрийн шинжилгээний ангиар явж, хуучны ном судар цуглуулахын зэрэгцээ монгол хэлний нутгийн аялгуу, ардын аман зохиолын хэрэглэгдэхүүн бүрдүүлэх ажлыг угсаатан судлалын хүрээнд хавсран гүйцэтгэж, монгол хэл бичгийн төдийгүй ардын аман зохиолын баялаг сан хөмрөгийг бүрдүүлэх үндэс суурийг тавьсан.

Монгол хэлний нутгийн аялгуу судлах ажлыг 1955 оноос эхэлсэн мэтээр судлаачид үздэг ч үнэн хэрэгтээ 1924 он гэхэд нутгийн аялгуу судлалын талаар нэлээд анхаарч, тодорхой хэмжээний ажлуудыг амжилттайгаар гүйцэтгэсэн мэдээ, баримтууд байна.

Монгол хэлний нутгийн аялгуу судлалаар хэдэн арван ганц сэдэвт бүтээл, олон тооны эрдэм шинжилгээний өгүүлэл, эх хэрэглэгдэхүүнтэй байгаа явдал нь Монгол улс дахь монгол хэл шинжлэлийн нутгийн аялгуу судлалын нэгэн гол амжилт юм. Энэ удаад бид монгол хэлний нутгийн аялгуу судлалын талаар баримтыг Монгол Улсын Үндэсний Төв архивын Түүхийн баримтын архивт хадгалагдаж буй хэрэглэгдэхүүнд тулгуурлан орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу судлах судалгааны ажлын тухай өгүүлэх болно.

Түлхүүр үг: Монгол Улс, ардын хувьсгал, нутгийн аялгуу, угсаатан зүй, дуун ухаан

E. Purevjav, M. Ochirtsend

LARIFYING REGIONAL DIALECT STUDIES IN MONGOLIA BY ARCHIVAL DOCUMENTS

***Summary*:** Within the framework of scientific institutions in Mongolia, the study of contemporary Mongolian regional dialects began legally in 1924, initially taking on a supplementary character to ethnographic research

to varying degrees. In the 1930s, the Five-Year Plan of the Folklore Cabinet of the Institute of Literature specifically emphasized the study of regional dialects and the organization of dialect surveys in rural areas. This indicates that during that period, there was a growing need to study the languages and dialects of ethnic groups in greater detail, driven by the political agenda of improving traditional scripts and adopting new writing systems. Consequently, considering the common characteristics of the population and ethnic groups, the Cyrillic script, based on the Khalkha dialect, was successfully introduced for public use. By the 1950s, regional dialect studies developed significantly as an independent scientific discipline, and a systematic, scientific examination of the spoken dialects of various ethnic groups in Mongolia began. By the 1960s, regional dialect studies in Mongolian linguistics reached a level where they were conducted using technical equipment and experimental phonetics, marking a notable scientific achievement in the field.

***Key words*:** Mongolia, People's Revolution, regional dialects, ethnography, folklore

Монголчууд бид эх хэлнийхээ зүй тогтол, хэл зүйн байдлыг судлан шинжилж ирсэн арвин баялаг уламжлалтай ард түмэн билээ. Тийм ч учраас бидний өвөг дээдэс төрт улсаа эмхлэн байгуулсан үеэс эх хэл, бичгээ төрийн бодлогын хэмжээнд тусгайлан авч үзэж, хэд хэдэн бичиг үсгийг зохион хэрэглэсэн зэрэг нь монголчууд хэл аялгуундаа хэрхэн анхаарч нарийн судлан шинжилсний илэрхий гэрч буй за. Аливаа бичиг үсэг зохион хэрэглэх нь нийгэм, эдийн засаг, хүн ам гэх мэт олон хүчин зүйлсээс шалтгаалах боловч эцэстээ аль нэг нутгийн аялгуунд тулгуурлан зохиогддог дохио тэмдгийн тогтолцоо юм.

1921 оны ардын хувьсгал ялсан даруй шинжлэх ухааны ууган байгууллага Судар бичгийн хүрээлэн байгуулагдаж, эрдэмтэн мэргэд эх хэлнийхээ нутгийн аялгууг шинжилж шинжлэх ухааны тогтолцоотойгоор судлах, хэл бичиг, утга зохиолын баялаг эх хэрэглэгдэхүүнийг цуглуулж, бүртгэн эмхэтгэх ажлыг гүйцэтгэн зохион байгуулж байв.

Монгол Улсын хэл бичгийн бодлогыг шийдвэрлэх төв байгууллага-Судар бичгийн хүрээлэн нь 1921 оны анхдугаар удаагийн хурлаар *"Монголын үндэсний хэлийг эрхэм болгомуй"* [МУҮТА, ТБА. Х-23, Д-1, ХН-6, Х-2.] хэмээх зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлж эхлүүлсэн ажлуудын тэргүүн эгнээнд тавигдсан ажлын нэг нь үсэг бичгийн талаарх бодлого байв. Чингэснээр монголчууд үсэг бичгийн асуудлаа төрийн бодлогын

салшгүй нэгэн хэсэг болгож ирсэн зуун зуун өртөөлөн дамнасан уламжлал ардын хувьсгалын дараагаас дахин сэргэж, утга зохиолын хэлийг улам төгөлдөржүүлэхэд эрдэмтэн мэргэд төдийгүй, төр засгийн зүгээс ихэд анхаарах болж, хуучин монгол үсгийг амьд ярианы хэлэнд ойртуулах, харь үгийг тэмдэглэхэд хялбар дөхөм болгох үүднээс латин үсэгт суурилсан шинэ бичиг авах талаар олон талын зорилтот ажлууд өрнөж эхэлсэн нь орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу судлах ажлын эхлэл болж, монгол хэл шинжлэлийн ууган салбаруудын нэг нутгийн аялгуу судлалын салбар ухаан бий болох шалтгаан болсон байна.

Нутгийн аялгуу судлал нь хэл шинжлэлийн авиа зүй, үгийн сан-утга судлал, хэл зүй, зөв бичих зүй, үсэг бичиг судлал зэрэг салбаруудтай нягт холбогдон, тухайн улс үндэстнийхээ хэлний хувьсал, өөрчлөлтийн толь болж байдаг тул хэлний хувьслын түүхийг тодруулах баримт болохын зэрэгцээгээр өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан хэлзүйн зүй тогтлыг бүрэн ажиглаж сайтар мэдсэнээр хэлний хувьслын ирээдүйн чиг баримжааг гаргах дүн шинжилгээ хийх боломжийг олгодог давуу талтай. Үндэстний хэл дотроо салбар аялгуу буюу хэд хэдэн нутгийн аялгуунаас бүрддэг ба тэдгээр нь эртний дурсгалт бичгүүд хийгээд эртний түүх, уран зохиол зэргийг уншихад ойлгогдохгүй үг хэллэг гарах тул дурсгал бичгүүдийг тайлж зөвөөр уншихад аль нэг нутгийн аялгуунд тухайн үг хадгалагдах жишээтэй байдаг. Мөн утга зохиолын хэлний баяжилт хэрэгцээнд голлох үүрэг гүйцэтгэдэг ба толь бичгүүдийг үйлдэхэд нутгийн аялгуу судлал чухал үүрэгтэйгээс гадна хэлний онол, хэлний гээгдэж хувирсан үзэгдэл, авианы хувьслыг таньж мэдэхэд эх хэрэглэгдэхүүн болж өгдөг онцлогтой. Үүнийг Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн мэргэд хэдийн ойлгон ухамсарласан байсан учир хүрээлэнгийнхээ гол хөтөлбөрийг боловсруулахдаа үндэстнийхээ хэл бичгийн бодлогод холбогдох заалтыг зүй ёсоор эрхэмлэн оруулжээ.

Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэд хүрээлэнгийн үйл ажиллагааны зорилтыг тусгасан хөтөлбөрийг “Эрхлэх үйлдвэрийн товчоо” нэртэйгээр боловсруулж, 1924 оны 3 дугаар сарын 23-ны өдөр батлан, түүнд тодорхойлон заасан зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байлаа.

“Эрхлэх үйлдвэрийн товчоо”-ны хоёрдугаар ангид монгол хэл бичгийн талаарх бодлогын гол цөм багтсаныг үзвэл,

“... ХОЁР. Монгол Улсын хэл ба бичиг , үүнд.

Нэг. Монгол үндэстний эдүгээ хэлж бүхий олон аймаг нутгийн тус тусын хэлний аяс ялгаврыг харилцан үлж, шинжлэх ба хэлний шинжлэгдэхүүн үгс зүйлийг хураан бүртгэмүй.

Хоёр. Монгол үндэстний хэлэн дээр бүхий амны зохиол зүйлийг бичиж авах ба бичгийн зохиолуудыг цуглуулан шинжилмүй. Эл зүйлийг бүртгэн шинжилсний дараа Судар бичгийн хүрээлэнгээс хичээвээс зохих нь.

Нэг. Монгол хэлний ёс дүрмийг шинжлэн илтгэж, дэлгэрэнгүй дэвтэр үйлдэх ба бас олон сургуульд үзэх монголын хэлний тольт зохиомуй.

Хоёр. Монгол үсэг бичгийн дүрмийг зохиох ба үгсийг зөв ёсоор бичсэн толь үйлдмүй.

Гурав. Монгол хэлний утгыг тодорхойлсон дэлгэрэнгүй тайлбар толь бичиг үйлдмүй.

Дөрөв. Монголын бичиг зохиолын зүйл хэрхэн анхнаас нааш дэлгэрсээр ирсний түүх зохиомуй.

Тав. Гадаад хэлнээс монгол бичиг хэлэнд орчуулахуйд хэрэгтэй шинэ нэр томьёоны толь бичиг үйлдмүй.

Зургаа. Монгол хэлний зохиол зүйлээс шилж сонгодог сайныг нь монгол ба гадаадын хэлэн дээр хэвлэн тархаамуй.

ГУРАВ. Монголын түүхийг шинжилсэн эрдэмтэн мэргэдийн зохиолуудыг олж авах ба монгол хэлэн дээр хөрвүүлмүй.

... *ТАВ.* Уран сайхны зүйлийг шинжлэхэд.

Нэг. Уран сайхнаар бүтээсэн юмс цуглуулах ба шинжлэх хийгээд Монголын хөг дууны аялгуу бичиж авмуй. Бас Монголын урнаа зурсан зургийн зүйл ба товойлгон бичиж бүтээсэн хийгээд урнаа сийлсэн зэргийг цуглуулмуй.*”* [МУҮТА, ТБА. Х-23, Д-1, ХН-3, Х-1-15.] хэмээн тус тус заажээ.

Энэхүү “Эрхлэх үйлдвэрийн товчоо”-нд хэл бичгийн талаар нэлээд нарийн тодорхой тусгасан зүйл бол монгол үндэсний олон аймаг нутгийн тус тусын хэлний аяс ялгаврыг харилцан адилтган шинжилж нутаг нутагт өвөрмөц хэлэгддэг үгсийг хураан тэмдэглэх тухай заасан явдал нь Монгол улсад нутгийн аялгуу судлах ажил албан ёсоор эхлүүлсэн хэрэг мөн. Эдгээр заалтууд нь монгол үндэсний нэгдмэл утга зохиолын хэлийг бүрдүүлэх цаг үеэ олсон бүтээлч ажил байсныг онцлон тэмдэглүүштэй. Мөн нэр томьёо оноох нь дан ганц орчуулах нэрлэхтэй холбоотой зүй биш бөгөөд монгол хэлний нутгийн аялгуунаас нэлээд олон нэр томьёог оноон хэрэглэж байсан явдал бол нутгийн аялгууны үгийг утга зохиолын хэлний идэвхтэй үгийн санд оруулж буй хэрэг юм. Монгол хэлний олон нутгийн аялгууны өвөрмөц үг хэллэг нь монгол утга зохиолын хэлийг баяжуулаг гол ундрага нь болж

өгдөг. Судар бичгийн хүрээлэнгийн тасгууд тухайн жилүүдэд Эрхлэх үйлдвэрийн товчоонд тусган оруулсан зорилтот хөтөлбөрийн хүрээнд хийж, гүйцэтгэх ажлаа төлөвлөн боловсруулж батлуулан ажилладаг байжээ. "Эрхлэх үйлдвэрийн товчоо"-ны хоёрдугаар ангид хэл бичгийн талаар заасанчлан тухайн жил монгол хэлний нутгийн аялгууны талаар нэлээд ажлыг гүйцэтгэсэн тухай 1924 оны илтгэлд тэмдэглэгдэн үлджээ. Тухайлбал: 1924 оны 10 сарын 5-ны өдрийн Судар бичгийн хүрээлэнгийн илтгэлд нутгийн аялгуу, аман зохиолтой холбогдуулан

"Манай Монгол Улсад олон шалгадаг ухааны эрдэм төдийлөн дэлгэрэх өдий болох тул мөнхүү элдэв ухааныг үзэх судар бичиг ер үгүйгээр үл барам шинжлэн үзэх түмэн бодис зэргийн нэр томьёог тогтож тодорхойлсон толь бичиг үгүй. Мөн эдгээр бодис зэргийн үлгэр маягийг цуглуулсан газрыг байгуулан олонд үзэхэд бэлтгэсэн зүйл үгүйн дээр шинэ цагийн шинжлэхүйн ухааныг ард түмэнд ухуулан мэдүүлж боловсруулахуйд маш бэрх билээ.Учир иймийн тул ардын засгийг анхан байгуулагдсаны дараа юуны урьд харьяат улсын эх түүх ба газар дэлхийн байдал хийгээд элдэв байгаль бодис, жич эрт ба эдүгээгийн магадыг олж, ард олонд дэлгэрүүлэн, соёлыг бадруулсугай хэмээн Судар бичгийн хүрээлэнг анхан үүсгэн Арван нэгдүгээр онд байгуулснаас хойш явуулан гүйцэтгэсээр ирснийг илтгэвээс:

... Долдугаарт. Монголын ахуй байдлыг шинжлэх тухай болбоос Монголын гүн дууны явдлыг шинжлүүлэн 130 гаруй аялгуу бичүүлэн хойшид мартахгүй болгон хадгалж, гүн дууны сургууль нээхэд бэлтгэжүхүй" [МУҮТА, ТБА. Х-23, Д-1, ХН-36, Х.1-21] гэж цохон тэмдэглэсэн нь орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу судлалыг үүсгэн хөгжүүлэх, хадгалан хамгаалах бодлогын түвшний ажил байсан хэмээн хэлж болох юм. Энэхүү 130 гаруй аялгууны бичлэг хаана хадгалагдаж байгаа эсэх талаарх мэдээлэл хомс тул цаашид улам нарийвчлан үзэж судлах шаардлага үүсэж буйг дурдах нь зүйтэй болов уу. Мөн академич Л.Болд "Нутгийн аялгуу судлалын тойм" өгүүлэлдээ "*1924-1925 онд Ховд аймгийн зарим сумд, Улаанбаатарын орчмоор, 1926 онд Төв, Булган аймгийн зарим нутгаар ажилласнаас хойш нутгийн аялгуу судлах талаар анхаарч, хөдөө орон нутагт шинжилгээний анги явуулан нэлээд арвин материал, "зарим тайлангаас үзвэл 30 орчим хэвлэлийн хуудас" бүрдүүлснээс үзэхэд тодорхой байна"*[Болд 2006: 99] хэмээн тэмдэглэсэн нь тухайн үед Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэд дан ганц ховор ном судар бичиг цуглуулах бус хэл бичиг, нутгийн аялгууны талаар нэлээд анхаарч байсны нэгэн илэрхийлэл юм.

Судар бичгийн хүрээлэн нь 1930 оны 12 сарын 20-нд БНМАУ-ын Бага Хурлын шийдвэрээр Шинжлэх ухааны хүрээлэн *(цаашид ШУХ гэж товчилно*) болон өргөжихөд Дууны ухааны тасаг нь Хэл бичгийн кабинет болон өөрчлөгджээ.

Судар бичгийн хүрээлэнгийн Дуун ухаан кабинет нь "Эрхлэх үйлдвэрийн товчоо"-нд заасан зорилтот ажлуудыг гүйцэтгэхдээ 5 жилээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж, монгол хэлний бичгийн болон судалгаа, шинжилгээний ажлыг сайжруулах талаар нэлээд идэвхтэй ажиллаж байсныг дараах баримт гэрчилнэ.

1930 оны 5 сарын 19-ний Судар бичгийн хүрээлэнгээс тогтоосон таван жилд гүйцэтгэвээс зохих хэрэг зүйлийн төлөвлөгөөний 2 бүлгийн 2-р зүйлд: Дуун ухааны кабинет ба түүний дэргэд бүхий Толь бичгийн, Нэр томьёоны байнгын комиссуудын гүйцэтгэвэл зохих ажлын төлөвлөгөөнд нутгийн аялгуу судлах шинжилгээний ажлын талаар нэлээд дэлгэрэнгүй заажээ. Үүнд:

Дөрөвдүгээрт,"Европын шинжлэх ухааны боловсон ёсоор монгол хэлний бүртгэсэн дэлгэрэнгүй толь бичиг зохиоход хэрэглэх материалыг идэвхийлэн бэлтгэх, Үүнд: Аливаа монгол бичгийн зохиол зүйлүүдийг шүүрдэн үзэхээс гадна, газар бүрийн хар хэлэн дээр хэрэглэж бүхүй нэр үгсийг ба утгыг тэмдэглэн цуглуулах";

Зургаадугаарт, "*Халх, ойрад, хотгойд, цахар, барга, буриад, дагуур, урианхай зэрэг тус бүрийн аялгуу бүхүй аймгуудын хэлний сунжсан, хувилсныг Холбоот улсын ШУА ба Буриадын соёлын хүрээлэн лүгээ хүч хавсарч шинжлэн гүйцэтгэх*";

Долоодугаарт, "*Холбоот улсын ШУА, Буриадын соёлын хүрээлэн хоёр лугаа нийлж Монгол аймгийн хар хэлний уран зохиолын зүйлийг урьд хэлэлцсэн ёсоор гүйцэтгэн явуулмуй*";

Есдүгээрт ,"*Жил бүр хэлний шинжилгээ үйлдэхээр нэг хоёр ангийг хөдөө явуулах*" [МУҮТА. ТБА. Х-23, Д-1, ХН- 204 Х.14-17] тухай тодорхой заасан байна.

Энэхүү төлөвлөгөөний Дөрөвдүгээрт заан тэмдэглэсэн хар хэлэн дээрх хэрэглэж бүхүй нэр үгсийн утгыг тэмдэглэн авах гэдэг нь нутгийн аялгууны өвөрмөц үг хэллэгийг тусгайлан заахын зэрэгцээ нэр томьёо онооход нутгийн аялгууны нэр үгийг шүүрдэн авч хэрэглэхээс гадна монгол утга зохиолын хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд оруулах зэрэг бүтээлч ажлуудыг багтаасан байна. Мөн Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэд нутгийн аялгуу гэж үзэхээс илүүтэй нэгдмэл үндэсний нэгдмэл утга зохиолын хэлийг буй болгох эрхэм зорилго тавин ажиллаж

байсны илэрхийлэл юм. Тухайн он жилүүдэд Монгол оронд уламжлалт үсэг бичгийг сайжруулах, шинэтгэх оролдлогоос гадна шинэ монгол үсгийг боловсруулах олон аман аялгууны үг хэллэгийг цуглуулж түүнд тулгуурласан хэл зүйн зарчмыг тогтоох зэрэг ажлыг манай эрдэмтэд хичээнгүйлэн гүйцэтгэж байв.

1941 онд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас гаргасан 22/18 дугаар тогтоолоор монгол бичгийг шинэ орос үсэгт шилжүүлэн авахыг чухал хэмээн үзэж, латин үсгийг судлах явдлыг зогсоож, шинээр төлөвлөсөн монгол үсгийн төлөвлөгөөг зөвшөөрч, орос үсэг дээр үндэслэсэн шинэ үсгийн төлөвлөгөөний хамтаар үсгийн дүрэм ба шинэ үсэгт шилжин орох хугацаа болон журмын тухай авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан тавих явдлыг Улсын Комисс ба ШУХ-д даалгасан байдаг.

Чухам энэ тогтоолтой холбогдуулан, кирилл үсэгт суурилсан шинэ үсэг зохиох тулгуур үзэл баримтлалын талаар хэл бичгийн ухааны эрдэмтэд "...*Монголын шинэ бичгийн хэлийг халх Монголын ярианы хэлийг түшиж монгол ардын одоогийн хэлийг үндэслэн зохиох хэрэгтэй гэсэн нам засгийн даалгаврыг яаж биелүүлэх вэ? гэвэл халх Монголын одоогийн ярианы хэлийг юуны өмнө судалж үзэх хэрэгтэй. Халх хүн юу гэж хэлдэг ярианг сонсох хэрэгтэй. Ардын юу гэж хэлдгийг чагнахгүй, ярианы хэлний дууг хайхрахгүй, дууны сургаалыг анхаарахгүй бол ардын ярианы хэлэнд ойрхон шинэ бичгийн хэлийг зохиох нөхцөлгүй болно*", "*Дууны сургаалгүй бол үгийн сургаал бас үгүй болно. Учир нь үгийн сургаалын ёсоор үгийн үндэс нөхцөлийг тогтоохдоо бас дууныг баримталж тогтоодог юм. Дууны сургаал бол үгийн сургаал, өгүүлбэрийн сургаал хоёрын үндэс болдог. Ийм учраас дууны бичигтэй улсуудын хэлний дүрэм дууны сургаал анхны бүлэг болж ороод үгийн сургаал, өгүүлбэрийн сургаал хоёрдугаар, гуравдугаар бүлэг болж ордог нийтийн тогтсон заншил байна*" [Очирцэнд нар 2021: 15] гэхчлэн нутгийн аялгуу аялгуу судлал гэдэг чухам ямар үнэ цэнтэй болохыг тодорхой өгүүлсэн сонирхолтой баримтууд байна.

Ардын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1941 оны 5 сарын 9-ний өдрийн хамтарсан 25/27 дугаар хурлын тогтоолоор орос үсэг дээр үндэслэн, Монголын шинэ үсгийг бүгд 35 үсгээр баталж, шинэ цагаан толгойн дүрмийн сурах бичгийг ойрын хугацаанд бэлтгэн гаргахыг Шинжлэх Ухааны Хүрээлэн, Ардыг гэгээрүүлэх яам (цаашид АГЯ гэж товчилно)-нд даалган, "...*Монголын шинэ үсгийг ард түмэн, албан хаагчдад өргөнөөр*

нэвтрүүлэн суралцуулах ажлыг зохиохыг бүх нам олон нийтийн ба улсын байгууллагад үүрэг болгосны зэрэгцээгээр Монголын шинэ үсгийг, бичиг үсгийг үл мэдэх явдлыг арилгах дугуйлан бүлгэмүүд ба цэрэгт эхлэн заах ба мөн бага сургуулийн хичээлийн жилээс эхлэн бүх хичээлийг шинэ үсгээр явуулж эхэлсэн" [Очирцэнд нар 2021: 15-16] байдаг. Мөн бүх сонинууд тусгай шинэ үсгийн булан байгуулж, шинэ монгол үсгээр өгүүлэл, материалуудыг хэвлэн явуулахыг сонинуудын эрхлэгч нарт даалгасны зэрэгцээгээр, "...шинэ үсгээр улсын хэмжээний бүх ажлыг гүйцэтгэх явдалд шилжин орох тухай төлөвлөгөөг нэг сарын дотор боловсруулан батлуулах"- ыг ШУХ, АГЯ-нд тус тус даалгаснаар шинэ үсэгт шилжих ажил үндсэндээ жигдэрчээ" [Очирцэнд нар 2021: 16]. Монголчууд бүх нийтээр халхын аман аялгуунд үндэслэн кирилл үсгийг авч хэрэглэсэн явдал бидний дээр өгүүлсэнчлэн, аливаа бичиг үсэг зохион хэрэглэх явдал аль нэг ярианы хэлний аман аялгууг гол болгон үзэж, түүний нийтлэг шинжийг сайтар ажиглан тогтолцоот чанарт тулгуурлан зохиогддог болохыг батлах зүйл юм. Манай улсын хэл бичгийн эрдэмтэд эх хэлнийхээ зүй тогтол, тогтолцоот шинжийг 1940 он гэхэд хэдийн таниж мэдэн бичиг үсэг зохиох хэмжээнд хүртлээ өсөн хөгжсөний углуурга нь Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтдийн залгамж холбоотой шууд хамааралтай

1945 онд Улсын их сургууль *(цаашид УИС гэж товчилно*)-д "*... Монгол хэл, утга зохиолын ангийг нээсэн явдал монгол хэлний шинжлэл, утга зохиолын судлалын ажлыг улам эрчимтэй хөгжүүлэхэд чухал нөхцөл болж*" [Вандуй 1965: 59], монгол хэлний шинжлэл, нутгийн аялгуу, үгийн сан, авиа зүй аман зохиол утга зохиол судлалын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэн судалгаа шинжилгээг бие даан гүйцэтгэх суурийг тавьсан билээ. 1948-1949 онд ЗСБНХУ-ын Шинжлэх ухааны академи, БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгийн хамтарсан шинжилгээний анги угсаатны зүйч эрдэмтэн К. В. Вяткинагийн удирдлагаар Ховд, Увс, Завхан, Архангай, Хэнтий, Чойбалсан, Сүхбаатар аймгуудаар угсаатан зүй, нутгийн аялгууны материалыг цуглуулсан бөгөөд тус ангийн бүрэлдэхүүнд УИС-ийн оюутан Т. Пагва, Х. Лувсанбалдан, Гомбожав нар оролцсон нь тухайн үеийн боловсон хүчний өсөлт хөгжилтийг хангахад анхаарч байсны илэрхийлэл байв.

1930-1940 онд үсэг бичгийг сайжруулах туршлагыг хуримтлуулсан, шинжлэх ухаанч үүднээс амьд хэл аялгуу, түүний хэл зүйн онцлог, үгсийн бүтцэд суурилсан шинэ монгол үсгийг зохион хэрэглээнд зорилтот алхмуудыг хийж байсан. 1940-1950 оны хооронд шинэ монгол

үсгийг олон нийтийн хэрэглээнд оруулж, орчин үеийн утга зохиолын хэл бүрэлдэн тогтох үндэс суурийг тавьсан” [Пүрэвжав, Очирцэнд 2021: 72] гэж хэлж болох юм.

ШУХ-ийн Тэргүүлэгчдийн 1954 оны сарын 22-ны өдрийн хурлаар Хэл бичгийн кабинетын 1953 онд хийсэн эрдэм шинжилгээний ажлын дүнгийн тухай хэлэлцэж гаргасан 4-р тогтоолын 8-р зүйлд: “... хөдөө орон нутагт экспедици явуулах замаар монгол хэлний аялгуу ба ардын аман зохиолыг судлах ажлыг зохиосугай” [МУҮТА, ТБА. Х-23, Д-2, ХН.104, Х.23-25.] хэмээн зааж, ажил хэрэг болгож эхэлжээ. Энэ хүрээнд Н. Шарав-Иш 1954 онд “Аман аялгуу судлах асуудал” нэртэй эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн нь дурдагдаж байна. [МУҮТА, ТБА. Х-23, Д-2, ХН.138, Х.1.]

ШУХ-ийн Тэргүүлэгчдийн 1955 оны 7 сарын 1-ний өдрийн хурлын 17-р тогтоолоор Хэл бичгийн кабинетаас нутгийн аялгуу судлах, аман зохиол цуглуулахаар Хэнтий, Сүхбаатар, Чойбалсан аймагт явуулах шинжилгээний ангийн төлөвлөгөөг баталсан нь анх удаагийн “Нутгийн аялгуу, аман зохиол судлах хээрийн шинжилгээний анги байлаа. Энэхүү анги нь дарьганга, халх, үзэмчин, барга аман аялгуу судлах, хэл шинжлэлийн газрын зураг гаргах, аман зохиолын материал цуглуулах, харшуулсан хэлний зүй зохиох, монгол шинэ үсгийн зарим асуудлыг шийдвэрлэх зэрэг зорилго тавьсан нь олон талын ач холбогдолтой байлаа. Мөн “...шинжилгээний анги нь үндсэн ажлын зэрэгцээгээр угсаатан зүйн судалгаа хийх, эрдэм шинжилгээний сурталчилгаа хийх ажлыг эрчимтэй хийх, газрын зураг үйлдэх, аймгуудын орон нутгийн кабинетын ажилд туслах, зааварлах, шалгах үүргийг гүйцэтгэдэг байжээ” [Пүрэвжав, Очирцэнд 2021: 73].

Тус ангийн тайланг БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгийн Тэргүүлэгчдийн 1955 оны 10 сарын 11-ний өдөр хурлын 23-р тогтоолоор хэлэлцээд, “...анхдугаар нутгийн аялгуу, аман зохиол судлах шинжилгээний ангийн ажлын амжилтыг сайшаан тэмдэглэсүгэй” [МУҮТА, ТБА. Х-23, Д-2, ХН-168, Х.12-14.] хэмээн өндрөөр үнэлсэн байдаг. Тус шинжилгээний анги нь “*түүхэн авиа зүй, түүхэн үг зүй, түүхэн үгсийн сан ба тэдгээрийн салангад асуудлыг шийдвэрлэхэд бичгийн дурсгалын зүйл, аман аялгуу хоёр ач холбогдлыг тодруулж харшуулсан хэлний зүйн*” материалыг цуглуулах, [Пүрэвжав, Очирцэнд, 2021: 73] зориулан биеэр ажиглан судлах, аман зохиолын материал цуглуулахад гол төлөв ажиглалтын журмыг баримталж байжээ. Үүнээс улбаалан шинжилгээний ангиуд тогтсон нэгдмэл энэхүү арга зүйгээр

1960-аад он хүртэл нутгийн аялгуу, аман зохиол цуглуулах ажлыг төлөвлөгдөн гүйцэтгэж ирсэн байна.

1956 онд Хөвсгөл, Завхан, Говь-Алтай аймгуудад Нутгийн аялгуу, аман зохиол цуглуулах Э. Вандуй [МУҮТА, ТБА. Х-23, Д-2, ХН-168, Х.37] ахлагчтай шинжилгээний ангийг 50 хоногийг хугацаатай томилон ажиллуулж, 1957 онд Өвөрхангай, Баянхонгор аймагт нутгийн аялгуу судлалаар шинжилгээний анги [МУҮТА, ТБА. Х-470, Д-1, ХН-13, Х.3-4], 1958 онд Ховд, Увс аймагт нутгийн аялгуу, аман зохиол угсаатны судлалаар Г. Ринчэнсамбуу [МУҮТА, ТБА. Х-23, Д-2, ХН-168, Х.54] ахлагчтай шинжилгээний ангийг 75 хоног, 1959 онд Хэнтий аймагт зарим сум, 1960 онд Архангай, Хөвсгөлийн зарим сумаар хээрийн шинжилгээний анги [МУҮТА, ТБА. Х-470, Д-1, ХН-13, Х.4] амжилттай ажиллуулж, нутгийн аялгууны материал цуглуулах нутгийн аялгууны хэлний зүй, үгийн сан, авиан зүйн ялгааг тодорхойлохыг оролдож байжээ.

Монгол хэлний хөгжлийн түүхийг судлахад бичгийн дурсгалын зүйл, нутгийн аялгуу хоёр үндсэн хэрэглэгдэхүүн болдог. Түүхэн хэл зүйн хамгийн баттай чухал материалыг гаргадаг эх булаг нь эдүгээгийн олон амьд аман аялгуу юм. Түүхэн авиа зүй, түүхэн үг зүй, түүхэн өгүүлбэр зүй, түүхэн үгсийн сангийн зүй ба тэдгээрийн салангид асуудлыг шийдвэрлэхэд бичгийн дурсгалын зүйл аман аялгуу хоёроор баримжаа болгон хувьсал хөгжлийг тодорхойлон гаргаж болох боломжтойг тухайн үеийн манай хэл шинжлэлийн эрдэмтэд хэдийнээ тунгаан боловсруулж, хээрийн шинжилгээний ангийн үндсэн ажилд хамруулсан явдлыг онцлон тэмдэглүүштэй.

1950-1960 он бол монгол хэл шинжлэлийн салбарт амьд хэл аялгуунаас хэлний түүхэн хөгжлийг тодорхойлох боломж нөхцөлийг бүрдүүлсэн он жил байсан төдийгүй нутгийн аялгууны салбар хүч түрэн хөгжих боломжийг бий болгосон түүхэн үе байлаа. Тухайн үед явсан хээрийн шинжилгээний ангийн үр дүн болгож А. Лувсандэндэв “Дарьганга аялгууны авиа зүйг судалсан туршлагаас” [Хэнтий, Сүхбаатар, Дорнод] (1957), Ш. Барайшир “Халхын аялгууны зарим хэсгийг судалсан тухай тэмдэглэл” [Өвөрхангай, Баянхонгор] (1957), Ш. Лувсанвандан “Монгол хэл аялгууны учир” (1959), Д. Цэнд “Монгол хэлний нутгийн аялгуу судлалын тойм” (1959) зэрэг бүтээл хэвлүүлжээ.

1956 онд Э. Вандуйгийн удирдсан эрдэм шинжилгээний анги тэр үеийн Говь-Алтай аймгийн Түмэн, Тайшир, Алдархаан, Чандмань, Эрдэнэхайрхан, Завханмандал, Идэр, Тэлмэн сумын нутгаар явж халх аялгууны авиа зүй, хэл зүй, үгсийн сан, аман зохиолыг анкетын

аргыг түүхэн харьцуулах аргатай хослуулан судалсан [Цолоо нар 2009: 82] байна. Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Ш. Барайшир, Ц. Өлзийхутаг нар оролцжээ. Цуглуулсан хэрэглэгдэхүүнээ боловсруулж Э. Вандуй "Зарим нутгийн аялгууны үгсийн сангийн бүрэлдэхүүний тухай" (1957), Ш. Барайшир "Зарим нутгийн аман аялгууны авиа зүйн тухай" зэрэг бүтээлийг нийтлүүлжээ. Э. Вандуй бүтээлдээ тухайн нутгийн халх аялгууны ерөнхий төлөв, авиалбарын тогтолцоог тоймлон судалжээ. Түүний сурвалжлан тэмдэглэж, орос, кирилл галиг, латин галигаар бичиж үлдээсэн халх, ойрад, буриад, барга зэрэг аман аялгуу, салбар аман аялгуу, аман зохиолын тайлан, өв Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны хөмрөг буюу Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй.

БНМАУ-ын Засгийн газрын 1957 оны 6 сарын 5-ны өдрийн шийдвэрийг үндэслэн, БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1957 оны 6 сарын 22-ны өдрийн 94 тоот зарлигаар ШУХ, УИС-ийг нэгтгэж Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн (*цаашид ШУДБХ гэж товчилно*) байгуулахад Хэл бичгийн кабинет нь Хэл бичиг, утга зохиол судлах газар болжээ. Чухам энэ үеэс монгол хэлний нутгийн аялгууг тогтолцоотой нарийн авиан зүйн үүднээс судлах шинжлэх ухааны шаардлага хэл бичгийн эрдэмтдэд тулгарчээ. Тухайн жилүүдэд шинжлэх ухаан төр засгийн бодлогын салшгүй нэгэн хэсэг болж байсан учир "*...ЗХУ болон ардын ардчилсан орнуудын их, дээд сургуульд 60 гаран мэргэжлээр хүмүүсийг сургах төлөвлөгөө байгаагаас ШУХ-ийн нэр дээр нутгийн аялгуу судлаачаар 1958 онд нэг оюутан захиалга өгсөн"* [Пунсалдулам нар 1921: 234] гэсэн мэдээ нь нутгийн аялгуу судлалыг монгол хэл шинжлэлийн бодлогын түвшинд авч үзэж байсны нэгэн жишээ болно.

1961 онд БНМАУ-ын Шинжлэх ухааны Академи байгуулагдахад Хэл бичиг, утга зохиол судлах газар нь анхны таван хүрээлэнгийн нэг - Хэл зохиолын хүрээлэн болж хэл, утга зохиол хэмээх хоёр үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахад хэлний тасагт нутгийн аялгуу судлах үүрэг, утга зохиолын тасагт аман зохиол судлах ажил ноогдож байлаа.

БНМАУ-ын Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэн, Унгарын ШУА хоёрын хооронд 1959 оны 10 сарын 14-д Улаанбаатар хотноо байгуулсан хамтран ажиллах хэлэлцээрийг хүчинтэйд тооцон, 1960 оны 11 сарын 03-ны өдөр Будапешт хотод гарын үсэг зуран баталгаажуулав [МУҮТА, ТБА. Х-23, Д-2, ХН-316, Х.63-65].

Уг хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн хавсралтад эрдэм шинжилгээний төхөөрөмж, техникийн материал, микрофильм фото-хуулбар, багаж хэрэглэлийн талаарх зардлыг БНМАУ ба БНУАУ-ын хоорондох Шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн үндсэн дээр тэдгээрийг авахыг хүссэн тал төлбөрийг гаргана [МУҮТА, ТБА. Х-23, Д-2, ХН-316, Х.70-72] гэж тогтсонтой холбоотойгоор Туршилт авианзүйн лабораторийн тоног төхөөрөмжийг Унгар улсаас авсан байдаг. 1960-аад оны эхнээс нутгийн аялгууг илүү тогтолцоотой нарийн судлах үүднээс Хэл зохиолын хүрээлэнгийн бүрэлдэхүүнд "Туршилт авиа зүйн лаборатори" байгуулах асуудал яригдаж, 1966 онд албан ёсоор нээж, эрхлэгчээр Ж. Цолоог томилон ажиллуулжээ. [МУҮТА, ТБА. Х- 470, Д-1, ХН-49, Х.9] Туршилт авиа зүйн арга нь тухайн үед авианы хэлэгдэх орчин бүтэх аргыг тагнайн зураг, кимограф, рентген аппарат, гэрэл зургийн аппарат зэрэг багажийг ашигладаг байжээ.

БНМАУ-ын ШУА-ийн Тэргүүлэгчдийн 1970 оны 3 сарын 23-ны өдрийн хурлын "Соёл, шинжлэх ухааны холбогдолтой бичмэл ном, дэвтэр өгсөн, ардын аман зохиол хэлж бичүүлсэн хүмүүст олгох шагналын тухай" журмыг баталсан тогтоолын Хавсралтын 3 дугаарт нутгийн аялгууны материал хэлж өгсөн хүмүүст дараах төрлийн урамшуулал олгохоор тогтоожээ. Үүнд:

"... 1. Авиа зүй, хэл зүй, үгийн сангийн талаар материал хэлж өгсөн хүнд хуудсанд (21 мөрөөр) 5-10 төгрөг,

2. Туршилт авиа зүйн аргаар тагнайн зураг, рентген зураг авахуулсан хүнд хортой нөхцөлд бол 3-10 төгрөг,

3. Нутгийн аялгууны тусгай текст буюу аман зохиол дуу хураагчид хэлж өгсөн хүнд 4, 5 хурдаар бодож, метр хальсанд (хоёр талдаа бичээстэй) 20 мөнгө,

4.Дуу хураагчаас ардын аман зохиолын аль нэгэн материал шинжилгээний галигаар буулгасан хүнд хуудсыг 75 мөнгө, шинэ үсгээр буулгасан хүнд хуудсыг 50 мөнгөөр тус тус бодож олгох зэргээр монгол нутгийн аялгуу, хэл соёлын талаар судлаач хийгээд судалгаанд оролцогчдыг урамшуулан дэмжиж байсан юм.

Мөн ардын аман зохиол, ховор ном судрыг бичиж тэмдэглэсэн, хуулбарласан, орчуулга хийсэн хүмүүст тодорхой хэмжээний мөнгөн урамшуулал олгодог байсан байна.

1. Гар бичмэл ном

а. Монгол ардын дуу, ерөөл, магтаал, үлгэр, тууль зэрэг ардын аман

зохиолын тухай бичиж тэмдэглэсэн 25 хүртэлх хуудастай нэг ном дэвтэрт 50-100 төгрөг, 50-аас дээш хуудастайд бол 100-200 төгрөг;

б. Дорно дахины хэл, түүх, уран зохиолын орчуулга 50 хүртэлх хуудастай бол 15-35 төгрөг, 50-аас дээш 35-100 төгрөг.

2. Ардын аман зохиол хэлж өгсөн хүмүүст

а. Тууль өгүүлэн хэлсэн хүнд мөр бүрд 10-20 мөнгө;

б. Үлгэр өгүүлэн хэлсэн хүнд хуудас бүр (21 мөрөөр) 1-5 төгрөг;

в. Түүхэн домог ширхэг нь 5 төгрөг;

г. Ерөөл магтаал хэлсэн хүнд мөр бүрд 10-15 мөнгө;

д. Ардын дуу хэлж аялсан хүнд бадаг буюу түрлэг бүрд 3-5 төгрөг;

е. Ардын уран таавар нэг бүр 3-5 төгрөг;

ё. Оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав зэрэг аман зохиолын жижиг төрөл зүйл нэг бүр нь 20-30 төгрөг;

ж. Хэл зүгшрүүлэх үг, асуух нурууны тухай, шатрын хожлын үг, дунд хуруу таах зэрэг ардын жүжиг наадмын зүйл ширхэг нь 2-5 төгрөг;

з. Бөөгийн аман яруу найраг, хэлж өгсөн хүнд мөр бүрд 50 мөнгөнөөс 1 төгрөг;

и. Хурим найр, үрс гаргах, шинэ дээл мялаах, төрөгсдийг угтах, үхэгсдийг үдэх, мэргэ төлөг, хараал зүхэл гэх зэрэг зан үйлийн холбогдолтой бусад жижиг зүйл хуудас нь шүлэглэсэн бол 25 мөрөөр, үргэлжилсэн үгээр бол 21 мөрөөр 1-5 төгрөг" [МУҮТА, ТБА. Х-23, Д-2, ХН-665, Х.87-91.] гэх мэт урамшууллыг өгч байсан байна.

Нутгийн аялгуу аман зохиол хоёр салангад мэт боловч аман зохиолын төрөл зүйлүүд нутгийн аялгууны судлалын цөм болж өгдөг. Аман зохиолын төрөл зүйлүүд нь угсаатны бүлгийн хэл аялгууны хэл зүйн шинж байдлыг тогтооход эх хэрэглэгдэхүүн болдог.

1970-аад оны үед хээрийн шинжилгээний ангиар цуглуулсан баримт, эх хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан нэгтгэж дүгнэсэн эрдэм шинжилгээ, судалгааны чанартай бүтээлүүд гарсан бөгөөд монгол нутгийн аялгуу, монгол соёл судлалтай холбогдолтой томоохон бүтээлч ажлын нэг бол академич Б. Ринчений удирдлагаар туурвисан "Монгол Ард Улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас" хэмээх хоёр боть бүтээл мөн. Тэргүүн ботид *"Монголын улс гүрэн, шавь, засаг захиргааны нэрс, угсаатны бүрэлдэхүүн, овгийн нэрс, сүм хийд, газар зүйн холбогдолтой нэрс, монгол хүний нэрс, Монголын аж байдлын холбогдолтой үгс*

зэрэг монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүний идэвхтэй ба идэвхгүй хэрэглээний уугуул монгол үг, нутгийн аялгууны үг, түүхэн үгийн хувилбар дуудлагыг хамарсан түүхэн хэл шинжлэлийн судлагдахуунууд” багтсан байдаг бол, Дэд боть нь *“Хэлний шинжлэл”* гэсэн ерөнхий гарчигтай бөгөөд *“Монгол хэлний халх, ойрад, буриад, үзэмчин зэрэг аялгууны эгшиг авианы хувьсал, хөгжил,гийгүүлэгч авианы хувьсал, хөгжил, байрлалыг тодорхойлсон”* байна.

Ж. Цолоо “БНМАУ-ын нутгийн аялгуу” (1987) хэмээх эрдэм шинжилгээний ганц сэдэвт бүтээлдээ орчин үеийн монгол хэлний хэл зүй, авиа зүй, үгийн сангийн судлалын талаарх монголч эрдэмтдийн судалгааг цаашид улам гүнзгийрүүлж, Монгол улсын монгол хэлний нутгийн аялгууны шинэ ангиллыг журамлан тогтоож өгсөн нь хэрэглээний чухал ач холбогдолтой болсныг онцлон дурдалтай. “БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг” (1988)-ийг халх аялгуу, ойрад аялгуу, буриад аялгуу гэсэн гурван ботиор туурвиж хэвлүүлэх санал санаачлагыг профессор Ж. Цолоо дэвшүүлэн гаргаснаар барахгүй, энэхүү орос хадмал орчуулга бүхий гурван боть том толь бичгийг туурвиж нийтлүүлэх судалгааны нүсэр ажлыг эхлүүлж, бодит ажил хэрэг болгож чаджээ. Эл суурь судалгааны бүтээлийн эхний хэсэг болох халх аялгууны нэгдүгээр ботийг доктор Б. Амаржаргал, хянан тохиолдуулагчаар академич Д. Төмөртогоо, доктор Г. Лувсан; II хэсэг болох ойрад аялгууны хоёрдугаар ботийг Ж. Цолоо, хянан тохиолдуулагчаар доктор Х. Лувсанбалдан; III хэсэг болох буриад аялгууны гуравдугаар ботийг профессор Г. Гантогтох, хянан тохиолдуулагчаар судлаач Н. Шарав-Иш ажилласан нь уг гурван боть толь бичгийн чанар чансаанд сайнаар нөлөөлсөн нь дамжиггүй.

Профессор Г. Гантогтох “БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг” хэмээх гурван боть бүтээлийн III боть буюу Буриад аялгууны толь бичгийг 2010 онд хэвлүүлсэн юм. Зохиогч толийнхоо оршилд “ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс удаа дараалан томилон явуулж цуглуулсан нутгийн аялгуу, аман зохиолыг судлах шинжилгээний ангийн хэрэглэгдэхүүнийг түшиглэн монголын утга зохиолын хэлнээс авиа зүй, үгийн сангийн онцлог бүхий 5550 толгой үгтэй буриад аялгууны толь бичгийг хэвлэлд шилжүүлсэн [Гантогтох 2010: 6] тухай тэмдэглэжээ.

1955 оноос хойш “Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр шинжлэх ухааны боловсронгуй арга зүйд тулгуурласан шинжилгээний ангиудыг гүйцэтгэсэн чиглэлийнх нь хувьд

авч үзвэл, “Нутгийн аялгуу судлах”, “Аман зохиол судлах”, “Ховор ном судар цуглуулах”, “Угсаатан зүйн атлас зохиох”, “Урлаг судлах”, “Нэр томьёо судлах” зэрэг чиглэлээр 100 гаруй хээрийн шинжилгээний ангийг албан ёсоор явуулж ажиллуулсан” [Пүрэвжав, Очирцэнд 2021: 76] байна. Эдгээр ангийг томилон явуулахдаа тодорхой тогтсон арга зүйг боловсруулан тодорхой зорилго, зорилтуудыг биелүүлэх үүргийг тусгаж, Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тухайн ангийн ахлагч, бүрэлдэхүүнийг томилж илгээхийн зэрэгцээ ирсэн даруй тухайн ангийн цуглуулсан баримт, боловсруулсан тайлан, үр дүн зэргийг Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцэж үндсэн үүрэгт ажлаа гүйцэтгэсэн эсэхийг нягталдаг сайн жишиг тогтсон байсан.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын шинжлэх ухааны байгууллагын хүрээнд орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу судлах ажил эрх зүйн хүрээнд 1924 оноос эхэлж, их бага хэмжээгээр угсаатан зүйн судалгааны хавсраг шинжтэй эхэлсэн байна. 1930-аад онд Судар бичгийн хүрээлэнгийн Дуун ухаан кабинетын таван жилийн төлөвлөгөөнд нутгийн аялгууг тусгайлан судлах, хөдөө орон нутагт нутгийн аялгууны анги явуулах тухай тодорхой тусган үзүүлснээс үзэхэд тухайн үед уламжлалт үсэг бичгийг сайжруулах, шинэ бичиг зохион хэрэглэх улс төрийн бодлогоос үүдэн угсаатны бүлгийн хэл аялгууг илүү нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага бий болсон байна. Ийм ч учраас хүн ам, угсаатны бүлгийн нийтлэг шинжийг харгалзан халхын аман аялгуунд суурилсан кирилл үсгийг зохион олон нийтийн хэрэглээнд амжилттай нэвтрүүлсэн.

Нутгийн аялгуу судлал бие даасан шинжлэх хэлбэрээр 1950-аад он гарсаар хүчтэй хөгжиж, Монгол Улс дахь угсаатны бүлгүүдийн аман аялгууг шинжлэх ухааны үүднээс нарийн тогтолцоотой тус бүрээр судлан шинжлэх ажил эхэлсэн байна. 1960-аад он гэхэд нутгийн аялгуу судлал техник төхөөрөмжид суурилсан туршилт авиан зүйн хэмжээнд судлах түвшинд хүрсэн монгол хэл шинжлэлийн нутгийн аялгуу судлалын шинжлэх ухааны нэгэн тэмдэглүүштэй амжилт байлаа.

НОМЗҮЙ

МУҮТА.ТБА. Х-23. Д-1. ХН.36.
МУҮТА.ТБА. Х-23. Д-2, ХН.104,138,168,316.
МУҮТА.ТБА. Х-470. Д-1, ХН.13, 49

Амаржаргал 1988: *Амаржаргал Б.* БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. I боть. Халх аялгуу. (Ред: Д. Төмөртогоо, Г. Лувсан). УБ., 1988.

Барайшир 1957: *Барайшир Ш*. Халх аялгууны зарим хэсгийн судалсан тухай тэмдэглэл. УБ., 1957.

Болд 2006: *Болд Л.* Хэл шинжлэлийн асуудлууд (Ред: Б. Түвшинтөгс). УБ., 2006.

Вандуй 1965: *Вандуй Э.* БНМАУ дахь нутгийн аялгууны судлалын тойм//"Шинжлэх ухааны академийн мэдээ". № 4. УБ., 1965.

Вандуй*: Вандуй Э.* Зарим нутгийн үгсийн сангийн тухай (Ред: Ш. Барайшир). УБ., 1957.

Гантогтох 2010: *Гантогтох Г*. Буриад аялгууны толь (Ред: Н. Шарав-Иш). УБ., 2010.

Лувсандэндэв 1957: *Лувсандэндэв А*. Дарьганга аялгууны авиа зүйг судалсан туршлагаас. УБ., 1957.

Очирцэнд, Энхбадрах 2021: *Очирцэнд М., Энхбадрах С.* Монгол хэл, бичгийн бодлогын баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2021.

Пунсалдулам нар 2021: *Пунсалдулам Б., Амарбаяр С., Энхжаргал Ц.* Монгол Улсын Шинжлэх ухааны түүх. II боть. УБ., 2021.

Пүрэвжав, Очирцэнд 2021: *Пүрэвжав Э, Очирцэнд М.* Хэл зохиолын хүрээлэн: 100 жил, 100 үйл явдал, 100 хээрийн шинжилгээний анги. -Монгол хэл, зохиол судлалын хөгжил, чиг хандлага. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. (Эмхэт, хэвл: Н. Мөнхцэцэг). УБ., 2021.

Ринчен 1979: Монгол Ард Улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас. Тэргүүн, Дэд боть (Эрхэл: академич Б. Ринчен). УБ., 1979.

Цолоо 1988: *Цолоо Ж.* БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. II боть (Ойрад аялгуу) /Ред: Х. Лувсанбалдан/. УБ., 1988.

Цолоо нар 2009: *Цолоо Ж., Ганбаатар Ж., Энхжаргал С.* Монгол хэлний нутгийн аялгуу судлал. "Монгол улсын Шинжлэх ухаан". 108 боть. XI боть. УБ., 2009.

Цэнд 1959: *Цэнд Д.* Монгол хэлний нутгийн аялгуу судлалын тойм. УБ., 1959.